



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2018.01.17 № 101/207

танай _____-ны № _____-т

ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ
МЭРГЭЖЛИЙН ТӨВ, АЙМАГ,
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ,
БҮСИЙН ОНОШИЛГОО,
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА,
ЗАХИРАЛ НАРТ

Албан даалгавар хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/143 дугаар тушаал, 2017 оны А/340 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, өнөөгийн байдалд үнэлгээ хийж, үнэлгээний тайланг Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2017 оны 04 сарын 27–ний өдөр, 2017 оны 12 дугаар сарын 18–ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гараад байна.

Иймд өөрийн байгууллагатай холбоотой арга хэмжээг 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган, хэрэгжилтийг хангаж, тайлан мэдээг тухай бүр ирүүлж ажиллана уу!

Хавсралт: 4 хуудастай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080301



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт,
хэвийн үйл ажиллагааг хангах тухай

Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2017 оны 04 сарын 27-ний өдөр, 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дараах албан даалгаврыг гаргалаа.

Албан даалгаврын дагуу арга хэмжээг авч, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдийн дарга, захирал нарт тус тус ДААЛГАСУГАЙ.

1. Монгол Улсын Шадар Сайдын 2015 оны 117 дугаартай “Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дугаартай тушаал “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх” журмын дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалт хийлгэх, шаардлагатай төсвийг тооцож, жил бүрийн төсөвт суулгах, хэрэгжилтийг хангаж ажиллах;

2. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/493 дугаартай тушаал “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ын дагуу Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийн санг шинэчлэн бүрдүүлж, сангийн үйл ажиллагааны тогтмол байдлыг хангаж ажиллах, тушаалын дагуу холбогдох мэргэжилтэнг томилон ажиллуулах;

3. 2017 онд шинэчлэгдэн батлагдсан бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчийн харьцааг хангах, нэмэгдүүлэх;

4. Салбарын хэмжээнд Хөрөнгийн төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоотой болох, хөрөнгийн оновчтой хуваарилалт, үр ашигтай зарцуулалттай болох шаардлагатай байгаа тул үндсэн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтний тоног төхөөрөмжтэй харьцан ажиллах чадварыг сайжруулах, ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээтэй холбоотой сургалтыг тогтмол зохион байгуулж, эмнэлгийн тоног төхөрөмжийн инженер, техникчдыг төгсөлтийн дараах болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах;

080012

5. Гэмтэлтэй байгаа болон ашиглагдахгүй байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг засварлах, хэвийн үйл ажиллагаанд оруулах, шаардлагатай байгаа эрүүл мэндийн байгууллагуудад шилжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг 2018 оны эхний хагас жилээр гаргаж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албанд ирүүлэх;

6. Мэргэжлийн хяналтын байгууллагын 2017 онд Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж, хадгалагдаж буй цацрагийн үүсгүүрийн хамгаалалт, аюулгүй байдалд хийсэн тандалт судалгаагаар дараах нийтлэг зөрчил илэрсэн: Үүнд:

- Ионжуулах цацрагийн үүсгүүрт ашиглах, хадгалах тусгай зөвшөөрөл аваагүй;

- Цацрагтай ажиллагчид, өвчтөн, үйлчлүүлэгчдийн цацрагийн нөлөөллөөс хамгаалах зориулалтын хувцас, хэрэгслийн хангамж, ашиглалт хангалтгүй;

- Цацрагтай ажиллагч эмч, рентген техникч нарыг мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад, мэргэжлээс шалтгаалах өвчний эмнэлгийн хяналтад тогтмол, бүрэн хамруулдаггүй;

- Цацрагийн хяналт, хэмжилтийн багаж байхгүй, ашиглалт хангалтгүй;

- Нарийн бүтэц зохион байгуулалттай тоног төхөөрөмжүүд болох MRI, CT, Ангиографийн аппарат дээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаагүй хүмүүс ажиллуулж байгаа;

- Цөмийн энергийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.3 дах заалт, “Рентген кабинет, ионжуулах туяа үүсгэгч аппарат төхөөрөмжийг ашиглах, суурилуулах болон рентген шинжилгээ хийх үед мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм” – ийн хэрэгжилт хангалтгүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн байна.

Иймд дээрх зөрчил дутагдлыг арилгах, холбогдох арга хэмжээг чиглэл тус бүрээр зохион байгуулах, хэрэгжилтийг эхний байдлаар 2018 оны 2 дугаар сарын 15–ны дотор гаргаж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албанд ирүүлэх;

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮД:

1. 2018 оны Улсын төсвийн урсгал зардалд өндөр технологи бүхий Соронзон резонанст томографи /MRI/, Компьютер томографи /CT/, Ангиографын аппаратын засвар, үйлчилгээний төсөв тусгагдсан тул тухайн тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай засвар үйлчилгээ болон бусад холбогдох арга хэмжээг төлөвлөгөө гарган зохион байгуулж, аппарат тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах, авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан мэдээг тухай бүр ирүүлэх;

2. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төв нь “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба”-ыг бэхжүүлэх, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 357 дугаар тушаалд заасан орон тоогоор бүтэц чиг үүргийн тодорхойлж, дутуу байгаа мэргэжилтэнг авч ажиллуулах;

21 АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР, НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ:

1. 11 аймгийн оношилгооны төвд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн баталгаат хугацаа дуусаж байгаа тул холбогдох арга хэмжээг авч, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах;

2. 11 аймгийн оношилгооны төвд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж дээр ажиллахаар сургалтад хамрагдаж, бэлтгэгдсэн эмч, мэргэжилтнээ 100 хувь ажиллуулах хэрэв ажиллаагүй тохиолдолд арга хэмжээ авах (дахин мэргэжилтэн бэлтгэх зардлыг тухайн байгууллагаас гаргах, тогтвор суурьшилтай ажиллаагүй төрийн сангаар сургагдсан мэргэжилтний сургалтын зардлыг төлүүлэх)

3. 2018 оны Улсын төсвийн урсгал зардалд 11 аймгийн оношилгооны төв байгуулах төслийн хүрээнд Компьютер томографийн аппарат /СТ/ нийлүүлэгдсэн Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Дорноговь, Сүхбаатар, Хөвсгөл аймгуудын Нэгдсэн эмнэлгийн төсөвт засвар, үйлчилгээний төсөв тусгагдсан тул холбогдох арга хэмжээг яаралтай зохион байгуулж, аппарат тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах, тайлан мэдээг тухай бүр ирүүлэх;

САЙД



Д.САРАНГЭРЭЛ